



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 431

Дадал сум

**“Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх”
тэмцэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.10, 18.2.12, 18.2.14, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Улсын Онцгой комиссын “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд хуурайшилтын “аюултай”, “нэн аюултай” зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, аялал зугаалгаар явах, ан агнах, байгалийн жамаар унасан бугын эвэр түүх, бусад үйл ажиллагааг тус тус хязгаарласугай.

2.Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудтай ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хариуцлагын гэрээ байгуулж, мод бэлтгэх явцад хяналт тавьж ажиллахыг Онон-Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (О.Цэндгомбо), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Батзориг) нарт даалгасугай.

3.Ойн тухай хуульд заасны дагуу ойд аялах, зугаалгаар явах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, байгалийн жамаар унасан бугын эвэр түүхгүй байхад хяналт тавьж, түймэр гарах эрсдэл өндөртэй бүс нутагт хөдөлгөөнт болон морин эргүүл зохион байгуулж, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, ой хээрийн гал түймэрт дайчлагдан ажиллах хүн хүч, тээврийн хэрэгслийг томилгоожуулан гал түймэр унтраах багаж хэрэгслийг бэлтгүүлэх ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, 7 хоног бүр танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын даргын дарга (Д.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000087